

Алхам 1. Цэгийн оронд холбох үгсийг нөхөж бичээрэй. \ 5 минут\

Монголчуудын талаарх Хятадын эртний нэгэн түүхэн бичигт тэдний хатааж ууталсан махыг олбоос хүнсэндээ хэрэглэж болно. хоолондоо чимхийн төдий хийвээс зохилтой. манай цэргүүд тэр махыг олж хэтрүүлэн хэрэглээд олноор гэдэс мушгирч үхэв" хэмээн бичсэн байдаг тухай эрдэмт ахаасаа сонсож байв. Хубилай хааны усан флот Япон тэнгист сүйрээд олон жилийн дараа уснаас гаргаж авсан жижиг арьсан богцны доторхийг шинжилбээс борц мах хадгалж байсан нь тогтоогдсон гэдэг юм. бидний дээдэс зөвхөн үхэр, тэмээ, ямааны махаа борцолж аян дайндаа авч явдаг байсангүй. Хойлогны мах хүртэл борцолж хатаагаад холын замдаа авч яваад харь дайсны мэсний шарх олсон үедээ идэж, хэдхэн өдөрт тэнхрэн босдог байжээ. бүр Чингис хаан зарлиг болсон мэдээ баримт ч бий гэнэлээ. "Махыг жижиг жижиг нарийн зүсэж, нар, салхинд өлгөн хатаах ба тийнхүү давсгүй хатаасан мах нь ямар ч үнэр танаргүй сайхан борц болно" гэж тэртээ 13-р зуунд шашин дэлгэрүүлэх нэрээр явсан, тагнуулч лам Гильом де Рубруккийн "Дорно этгээдэд зорчсон минь" номондоо тэмдэглэсэн байдаг юм. эртнээс хийж хэрэглэж, биднийхээ хоол хүнсэнд бүрэн дасан зохицсон махан хүнсээ одоо цагт хор мэтээр өөлөн бичигчдэд өс санадаггүй ч ер би дургүй хүн. бид мэт байтугай биднээс хол явж, нэр олсон зүйл маань борц.

Нөхөх үгс: гэтэл, энэ тухай, нэгэн удаа, ийм л, гэвч, мөн, тэгээд ч, тэгж ярих юм бол

976-7577 8081

www.info@e-school.edu.mn

www.e-school.edu.mn